

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/66/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2024 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 7042293 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: В.Хуандых Утас: 99426960 Цахим хаяг: khuash69@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-2954 E-mail: bayanulgi@audit.gov.mn	ЦЭНГЭЛ СУМЫН ХҮҮХДИЙН 4 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ К.БАЛМИРА ТАНАА
<p>2024.02.06 № 24 танай _____ -ны № _____ -т</p>	
Өөрчлөлтгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Асуудлыг онцолсон хэсэг	
<p>Цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.</p>	
Аудитын гол асуудал	
<p>Цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.</p>	
Бусад асуудлын хэсэг	
<p>Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.</p>	

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

СТ-1А

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>32,131,944.00</u>	<u>115,989,879.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	16,905,154.00	97,357,329.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	16,905,154.00	97,357,329.00
3121	Төгрөг	16,905,154.00	97,357,329.00
31211	Төрийн сангийн харилцах	16,905,154.00	97,357,329.00
35	БАРАА МАТЕРИАЛ	15,226,790.00	18,632,550.00
354	Хангамжийн материал	15,226,790.00	18,632,550.00
35410	Бичиг хэргийн материал	200,000.00	-
35420	Аж ахуйн материал	11,003,000.00	11,103,000.00
35440	Түлш, шатах тослох материал	545,000.00	1,695,000.00
35460	Хүнсний материал	3,478,790.00	5,834,550.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>355,057,510.56</u>	<u>341,787,259.40</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	355,057,510.56	341,787,259.40
392	Биет хөрөнгө	355,057,510.56	341,787,259.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	358,000,000.00	358,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(17,154,166.59)	(26,104,166.55)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	14,334,195.00	14,334,195.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(4,836,262.41)	(7,737,185.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,096,643.00	7,096,643.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,382,898.44)	(3,802,227.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>387,189,454.56</u>	<u>457,777,138.40</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,110,000.00</u>	<u>432,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,110,000.00	432,000.00
413	Өглөг	2,110,000.00	432,000.00
4136	Бусад өглөг	2,110,000.00	432,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	432,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,110,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>385,079,454.56</u>	<u>457,345,138.40</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>385,079,454.56</u>	<u>457,345,138.40</u>
512	Хуримтлагдсан үр дүн	<u>385,079,454.56</u>	<u>457,345,138.40</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	382,570,610.21	385,079,454.56
51220	Тайлант үеийн үр дүн	2,508,844.35	72,265,683.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>387,189,454.56</u>	<u>457,777,138.40</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	272,056,300.00	419,066,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-
120	Нийтлэг татварын бус орлого	-	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	272,056,300.00	419,066,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	240,821,200.00	405,616,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	240,821,200.00	405,616,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31,131,600.00	13,450,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31,131,600.00	13,450,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	269,547,455.65	346,800,416.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	269,547,455.65	346,800,416.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	267,503,083.65	346,800,416.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	190,153,082.00	248,566,025.00
210101	Үндсэн цалин	164,346,487.15	193,762,760.00
210102	Нэмэгдэл	16,904,294.85	37,926,117.00
210104	Урамшуулал	8,902,300.00	16,877,148.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,707,000.00	33,760,200.00
210201	Тэтгэврийн даатгал	18,391,800.00	22,957,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,078,900.00	2,701,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,662,900.00	2,160,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	415,900.00	539,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,157,500.00	5,401,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,475,019.00	10,040,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,973,719.00	1,781,914.00
210302	Түлш, халаалт	4,426,500.00	7,258,086.00
210303	Цэвэр, бохир ус	74,800.00	1,000,000.00
2105	Нормативт зардал	25,709,230.00	33,524,640.00
210502	Хоол, хүнс	25,709,230.00	33,524,640.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	444,000.00	543,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	444,000.00	543,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,014,752.65	20,366,051.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,515,510.00	5,473,330.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,496,250.00	1,622,470.00

Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,002,992.65	13,270,251.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,044,372.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,738,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,738,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	306,372.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	306,372.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,508,844.35	72,265,683.84
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,508,844.35	72,265,683.84

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	272,056,300.00	419,066,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	272,056,300.00	419,066,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	240,821,200.00	405,616,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	240,821,200.00	405,616,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31,131,600.00	13,450,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	31,131,600.00	13,450,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	255,151,146.00	338,613,925.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	255,151,146.00	338,613,925.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	253,106,774.00	338,613,925.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	186,787,255.00	248,566,025.00
210101	Үндсэн цалин	160,980,660.15	193,762,760.00
210102	Нэмэгдэл	16,904,294.85	37,926,117.00
210104	Урамшуулал	8,902,300.00	16,877,148.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,707,000.00	33,760,200.00
210201	Тэтгэврийн даатгал	18,391,800.00	22,957,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,078,900.00	2,701,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,662,900.00	2,160,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	415,900.00	539,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,157,500.00	5,401,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол	6,838,619.00	13,300,000.00

Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

	зардал		
210301	Гэрэл, цахилгаан	1,973,719.00	1,781,914.00
210302	Түлш, халаалт	4,790,100.00	10,518,086.00
210303	Цэвэр, бохир ус	74,800.00	1,000,000.00
2105	Нормативт зардал	25,441,800.00	35,880,400.00
210502	Хоол, хүнс	25,441,800.00	35,880,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,800.00	150,000.00
210604	Урсгал засвар	100,800.00	150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	444,000.00	543,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	444,000.00	543,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,787,300.00	6,413,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,302,300.00	4,783,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,485,000.00	1,630,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,044,372.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,738,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,738,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	306,372.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	306,372.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>16,905,154.00</u>	<u>80,452,175.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	16,905,154.00	80,452,175.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		16,905,154.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,905,154.00	97,357,329.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
С01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			382,570,610.21		382,570,610.21
С02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
С03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	382,570,610.21	0.00	382,570,610.21
С04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
С05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
С06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00

Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

C07	Тайлант үеийн үр дүн			2,508,844.35		2,508,844.35
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	385,079,454.56	0.00	385,079,454.56
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	385,079,454.56	0.00	385,079,454.56
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00		0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	385,079,454.56	0.00	385,079,454.56
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			72,265,683.84		72,265,683.84
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	457,345,138.40	0.00	457,345,138.40

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		16,905,154.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	435,971,254.00	338,613,925.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	435,971,254.00	338,613,925.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	435,971,254.00	338,613,925.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	330,292,254.00	248,566,025.00
210101	Үндсэн цалин	210,340,154.00	193,762,760.00
210102	Нэмэгдэл	102,348,100.00	37,926,117.00
210104	Урамшуулал	17,604,000.00	16,877,148.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,492,700.00	33,760,200.00
210201	Тэтгэврийн даатгал	29,575,300.00	22,957,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,479,900.00	2,701,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,783,400.00	2,160,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	695,300.00	539,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,958,800.00	5,401,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,300,000.00	13,300,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,700,000.00	1,781,914.00
210302	Түлш, халаалт	10,600,000.00	10,518,086.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00

Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	38,871,000.00	35,880,400.00
210502	Хоол, хүнс	38,871,000.00	35,880,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	150,000.00	150,000.00
210604	Урсгал засвар	150,000.00	150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	543,500.00	543,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	543,500.00	543,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,321,800.00	6,413,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,691,400.00	4,783,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,630,400.00	1,630,200.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	419,066,100.00	419,066,100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	405,616,100.00	405,616,100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	405,616,100.00	405,616,100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	13,450,000.00	13,450,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	13,450,000.00	13,450,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		16,905,154.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		97,357,329.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20.00	20.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00
620004	Гэрээт ажилтан	2.00	2.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1.00	1.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	1.00	1.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	1.00	1.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	20.00	20.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	7.00	7.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00
650010	Гэрээт ажилтан	2.00	2.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Цэцэрлэг нь “Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилан цэцэрлэгийн менежментийг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарт ахиц гаргах” зорилгын хүрээнд “Ээлжит хичээлийг чанаржуулах”, “Хүүхдийн насны онцлогт тохируулан хөгжүүлж, эрүүл сааруул эсэн мэнд асран хамгаалж хүүхдийн хөгжлийг дэмжин нийгэмшүүлж бие хүн болгон төлөвшүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэцэрлэг нь Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккрузал суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийгдээгүй байна.

Цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжгүй ба захирлын тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 70.6 сая төгрөгөөр буюу 18.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	16905.2	97357.3	80452.1
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	15226.8	18632.6	3405.8
Үндсэн хөрөнгө	355057.5	341787.3	-13270.2
Нийт хөрөнгө	387189.5	457777.1	70587.6
Өр төлбөр	2110	432	-1678
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	385079.5	457345.1	72265.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	387189.5	457777.1	70587.6

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эцэст 97.3 сая төгрөг болж оны эхнээс 80.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүний 81.7 сая төгрөг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн, 9.7 сая төгрөг нь хүүхдийн хоолны зардлын төсвөөс үлдсэн мөнгө байна.

Бараа материал дансны үлдэгдэл оны эцэст 18.6 сая төгрөг болж 3.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: хүнсний материалын үлдэгдэл 5.8 сая төгрөг, аж ахуйн материал 11.1 сая төгрөг, түлш, шатах тослох материал 1.7 сая төгрөг байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 341.8 сая төгрөг болж 13.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 13.2 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Оны эцэст 0.4 сая төгрөгийн өглөгтэй гарсан нь байгууллагад төлөх өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 457.3 сая төгрөг болж 72.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 72.3 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 353.9 сая, орон нутгийн төсвөөс 17.5 сая, нийт зарлагыг 371.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас цэцэрлэгийн 2023 оны хувьсах зардлын төсвийг 323.6 сая төгрөгөөр хянаж, 30.3 сая төгрөгөөр бууруулж баталсан ба төсвийн тодотголоор 112.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 436.0 сая төгрөг болгон тодотгож баталжээ.

Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 13.5 сая төгрөгөөр баталж, тодотголоор өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 422.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 13.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийтдээ 436.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 422.5 сая, орон нутгийн төсвөөс 13.5 сая нийтдээ 436.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 338.6 сая төгрөг / 77.7 хувьтай / буюу дансанд 97.3 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		/мянган төгрөгөөр/			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605	Эрүүл мэндийг дэмжих	815.2	815.2	0	100%
2	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	38871.0	35880.4	2990.6	92.3%
3	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2392.6	0	2392.6	0%
4	81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	816.7	300.0	515.2	36.8%
5	81834	Боловсролын стандарт, сургалтын	207556.9	170764.0	36792.9	82.3%
6	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	172068.8	117404.3	54664.5	68.2%
7	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	13450.0	13450.0	0	100%
Нийт дүн			435971.2	338613.9	97357.3	77.7%

Цэцэрлэгийн төсвийн гүйцэтгэл нь төлөвлөснөөс 97.4 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарчээ. Үүнд: цалингийн зардал 81.7 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 9.7 сая, нормативт зардал 3.0 сая, бараа, үйлчилгээний бусад зардал 2.9 сая нийтдээ 97.4 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Цэцэрлэг нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 49.5 сая төгрөгийн бараа материал худалдан авсан, үндсэн хөрөнгө худалдан аваагүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цэнгэл сумын хүүхдийн

Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ний аудитор В.Хуандых гүйцэтгэж, анхан шатны хяналтыг “Уужим алтай Аудит” захирал Б.Галымбек, дараагийн шатны хяналтыг аудитын менежер Х.Женисбек, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн Б/01 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 269.5 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 5.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллааа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын FAS программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 381.2 сая төгрөгийн 25 мөнгөн гүйлгээ хийгдсэнээс 362.1 сая төгрөгийн орлогын гүйлгээг шилэн дансанд мэдээлж, 19.1 сая төгрөгийн орлогын гүйлгээг дутуу мэдээлсэн. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 80.8%-тай байна.

Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Цэцэрлэгийн эрхлэгчийн төсөв, өмч, хөрөнгө зарцуулах тушаалаар гарсан 10.0 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлт олгохтой холбоотой тушаалын гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй, шийдвэрийг санхүүгийн баримтад хавсаргаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.....”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ...” заасны дагуу мэдээллийг хугацаанд мэдээлж ажиллах, хувь хүний мэдээлэлтэй холбоотой тушаалыг шилэн дансанд байршуулахгүй байх талаар зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар цэцэрлэгийн өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг болон нярвын тайланг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 72.3 сая төгрөгийн тайлант оны үр дүнг өмнөх оны үр дүнтэй хамт тайлагнасан алдааг илрүүлж, залруулсан. Мөн 2023 оны санхүүгийн байдлын тайлангийн хуримтлагдсан үр дүнгийн эхний үлдэгдэл зөрүүтэй тайлагнасан алдааг тайлан хүлээн авах хугацааны явцад залруулж ажилласан байна.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар цалингийн зардлаас ажилтнуудад 10.0 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант оны худалдан авсан бараа материалын тооцоо 0.5 сая төгрөгийн зөрүүтэй, тээвэр шатахууны зарцуулалтын анхан шатны баримтыг баримтжуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.1. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.7 дахь заалтуудыг мөрдөж, санхүүгийн тайланд хүчин төгөлдөр бүхий анхан шатны баримтыг хүлээн зөвшөөрч бүртгэх, ажил олгогч ажилтанд цалин хөлс олгох бүрд тухайн хугацаанд олговол зохих цалин хөлсний бүрэлдэхүүн, суутгалын хэмжээ, түүний үндэслэл, олгосон цалин хөлсний хэмжээг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх

3. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Цахилгаан, бохир ус, байр ашиглалтын 3.1 сая, шуудан холбоо, түлш шатахууны 1.4 сая, сургалт, аудит төлбөр зэрэг бусад зардлын 2.6 сая, нийт 7.1 сая төгрөгийн зардлыг тооцооны данс дамжуулан тооцоо хийгээгүй, шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

3.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.2, 20.2, 20.2.5 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж аливаа гүйлгээг тооцооны данс дамжуулан бүртгэж тайлагнах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант үед гарсан үр дүнг өмнөх үеийн үр дүнтэй хамт тайлагнасан.	1	72,265.7					1	72,265.7				
Дүн	1	72,265.7					1	72,265.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж							
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн зардлаас ажилтнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон	1	10,000.0					1	10,000.0						
Нярвын тайлан санхүүгийн	1	446.3					1	446.3						

Цэнгэл сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

тайлангийн бараа материалын тодруулга тайлантай зөрүүтэй										
Зарим зардлыг тооцооны дансаар дамжуулан тооцоо хийгээгүй шууд зардлаар бүртгэсэн	1	7,057.7				1	7,057.7			
Дүн	3	17,504.0				3	17,504.0			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарах шийдвэрийг байршуулаагүй	1	10000.0					1	10000.0
Дүн	1	10000.0					1	10000.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								